2021 12 31
56/6

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 19 өдөр Дугаар 6/08 Өвт

## Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "д" заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2, Сангийн сайд, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалаар баталсан "Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал"-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэгдүгээр хавсралтаар, энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын хэмжээг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн батлагдсан хэмжээг албан байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд, айл өрхүүдэд сурталчлан таниулах, даган мөрдүүлж хэрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (С.Амгалан), "Бат-Өлзий тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын дарга (Г.Бямбагарав) нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж, мөрдсүгэй.

5. Тогтоолыг хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ж.Чимэддулам)-д даалгасугай.

ДАРГА Д.ЦЭРЭНТОГТОХ

My Dok D-A-4 togtool /ITKH/2021

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
20.21. оны .12 сарын 19. өдрийн 6/02 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт

## Бат-Өлзий суманд мөрдөх Хог хаягдлын үйлчилгээний хураамж

| № | Үйлчилгээний төрлүүд | | Хэмжих нэгж, нэг сарын төлбөр | Төлбөр /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| 1 | Орон сууц, гэр хорооллын айл өрх | | Нэг сарын төлбөр | 1800 |
| 2 | Нийтийн орон сууцанд амьдардаг айл өрх | | Нэг сарын төлбөр | 2430 |
| 3 | Сумын төвд хашаандаа мал бүхий айл өрхийн хонин толгойд шилжүүлснээр | | Жилд | 2592 |
| 4 | Худалдаа үйлчилгээ | Хүнсний дэлгүүр 8-н нэрийн | 40м/кв-аас дээш | 7700 |
| | | Хүнсний дэлгүүр 6-н нэрийн | 40м/кв- хүртэл | 3850 |
| | | Эмийн сан | 40м/кв-аас дээш | 7700 |
| | | Мини маркет | 60м/кв-аас дээш | 11500 |
| | | Супер маркет | 80м/кв-аас дээш | 15300 |
| | | Цайны газар, Зоогийн газар, баар, ресторан | 20 хүртэл суудалтай | 14400 |
| | | | 21-40 суудалтай | 21960 |
| | | | 41-ээс дээш суудалтай | 29520 |
| 5 | Зочид буудал амралт, сувилал /Хүн өдрөөр 254,4 өдөр/ | | 10 хүртэл ортой | 7632 |
| | | | 20 хүртэл ортой | 15264 |
| | Жуулчны бааз, дэн буудал, эко гэр /хүн өдөр 120 өдөр/ | | 10 хүртэл гэр /50 ор/ | 54000 |
| | | | 15 хүртэл гэр /75 ор/ | 81000 |
| 6 | Сургууль, цэцэрлэг | | Хүүхдийн тоо | 1152 |
| 7 | Хүн эмнэлэг | | Ор хоног | 8640 |
| 8 | Албан байгууллага | | Орон тоо | 1520 |
| 9 | Дугуй засвар, авто угаалга | | Нэг сарын төлбөр | 4800 |
| 10 | Шатахуун түгээх станц, засварын газар талбайн / метр квадрат/ | | Нэг сарын төлбөр | 10000 |
| 11 | Барилга угсралт болон бусад ажилд | | Метр квадрат | 1200 |
| 12 | Дээрх ангилалд ороогүй бусад үйл ажиллагааг | | Ашигтай талбайгаар | 2760 |

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
20.21. оны 12 сарын 19. өдрийн 6/08 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх зардлын нэгж тариф

| Үзүүлэлтүүд | Нэгж | Хэмжээ |
|---|---|---|
| Нэг рейсийн тээвэрлэлтийн дундаж зай | км | 25 |
| Хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын норм | Км/л | 12 |
| Нэг рэйсд хийх хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын дундаж | км/л | 3 |
| Ачилтын үеийн шатахуун зарцуулалтын норм | Мин/л | 0.05 |
| Ачилтын үеийн цаг ашиглалт | Мин | 40 |
| Ачилтын үеийн шатахуун зарцуулалт | Мин/л | 2 |
| Шатахууны үнэ | Төг/л | 2930 |
| Нэг рейст зарцуулах шатахуун | Төг/л | 14650 |
| Ажиллах хугацааны үндсэн цалин | Төг/рейс | 6364 |
| Ажилтны багаж хэрэгсэл | Төг/рейс | 1500 |
| Нэг рейсд шаардагдах зардал | төг/рэйс | 30579 |
| Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардал | Төг/рейс | 2130 |
| Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал | Төг/рейс | 5935 |
| Нэг рейст ачиж тээвэрлэх хогийн дундаж хэмжээ | төг/Тн | 2 |
| Нэг тонн хогийг тээвэрлэх зардал | Тн/төг | 15286 |

“Бат-Өлзий тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазарын судалгаа мэдээллийг үндэслэн Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан аргачлалаар тооцов.

Тайлбар: 1 портер ачааны машинд 2 тонн хог бүхэл дүнгээр 30000 төгрөгийн зардал, 8-10 поошиг /1 поошиг нь 200л багтаамжтай/ хог ордог учир 1 поошиг хогны дундаж зардал 3000 төгрөгөөр тооцохоор байна. Цэвэрлэх, тээвэрлэх, ажилд машин техникийн марк, тухайн үеийн зах зээлийн шатахууны үнэ ханшнаас хамаараад тариф хэлбэлзэж болно.